



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ТӨМӨРХҮҮ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

Хөр. 02.15 № 09/28 УАТ-САТ/2012/ХЧ-СТА-ТОУГ

3

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ.

- “УБЦТС” ТӨХК-н 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 1,905.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 14,466.1 сая төгрөгийн дансны авлага, 4,627.2 сая төгрөгийн дансны өглөг тусгагдсан байна. Аудитаар харилцагч банктai үлдэгдэл нийлсэн баримттай, кассын тооллогын баримттай, дансны авлагын үлдэгдлийг эзэн хариуцагч нь төлөхөөр хүлээн зөвшөөрсөн бичгэн баталгаа буюу тооцоо нийлсэн акттай, дансны өглөгийн үлдэгдлийг эзэн холбогдогчоос нь нэхэмжилсэн тухай бичгэн баталгаа буюу үлдэгдлийг баталгаажуулсан албан ёсны баримттай, төв компани ба салбар нэгжүүдээс ирүүлсэн тулгалтын баримттай нь нэг бүрчлэн тулгасан бөгөөд 585.1 сая төгрөгийн харилцахын үлдэгдэл буюу 30.7 хувь, 13.4 сая төгрөгийн дансны авлага (үүнд ЦЭХ хэрэглэгч 210 мянга гаруй хэрэглэгчийн авлага орсон) буюу 92.8 хувь, 2,127.8 сая төгрөгийн дансны өглөг буюу 46.0 хувь зэрэг нийт 16,140.0 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
- 2012 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд нийт 171.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлагнасан. Гэвч үндсэн хөрөнгийг ангилж программ хангамж, бүртгэлд тусгасан байдал, элэгдлийн тооцоололд ашиглаж буй хувь хэмжээ зөрүүтэй, үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үндсэн хөрөнгийн тооллогын чанар хангалтгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ихээхэн үлдэгдэлтэй байна.
- Нийт 26,321.1 сая төгрөгийн дуусаагүй барилга дансны үлдэгдэлтэй байна. Гэвч тайлангийн хугацаанд их засварын болон бусад барилгын ажил нь хийгдэж дууссан эсэх, гүйцэтгэл нь ямар шатанд байгаа нь тодорхойгүй, дууссан гэх боловч холбогдох тооцоог хийгээгүй, ажлын комиссын хүлээн авах акт бичигдээгүй, бараа материалын шинж чанартай хөрөнгө бүртгэгдсэн, 2012 оны жилийн эцсийн тооллогонд хамрагдаагүй зэрэг шалтгаанаар аудитаар дуусаагүй барилга дансны үлдэгдэл бүрэн хэмжээгээр баталгаажигдахгүй байна.
- Кассын бэлэн мөнгөний 579.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг анхан шатны баримтаар гүйлгээ хийхэд үндэслэл болгосон дагалдах баримтын иж бүрдэл, хүчин төгөлдөр байдал хангалтгүй, зарлагын гүйлгээний утга, агуулга тодорхойгүй бичигдсэн, баримт нь эмх цэгцгүй үдэгдсэн, мөн дараа тайлангийн гүйцэтгэлийн нотлох баримтын иж бүрдэл хангалтгүй, буцалтгүй тусламж, томилолтын мөнгө олгосон ба дараа тайлангийн баримтанд мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй, томилолтын зочид буудал хоол, унаанд

070081

зарцуулсан төлбөрийг нотолсон баримтгүй зэрэг 138.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал: Зуунмод ХҮТ болон ТТ-д 2 орон сууц худалдан авахад олгосон 88.4 сая төгрөгийн зардлын гүйлгээний баримтанд Зуунмод ХҮТ болон ТТ-с ирүүлсэн санхүүжилт гэсэн нэхэмжлэхийг хавсаргасан өөр баримтгүй байсан.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.3 дахь "...нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах...", 19.1.5 дахь "...эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх.....", Нягтлан бодох бүртгэлийн олон улсын 16 дугаар стандартын 6-10 дугаар, 37,43-59 дүгээр заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн дээрх зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт болон Далайван аудит ХХК-д ирүүлэхийг тус компаний Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Баясгалан, ахлах нягтлан бодогч У.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

**ДАЛАЙВАН АУДИТ ХХК
ЗАХИРАЛ**



Л.ОДГЭРЭЛ

Ц.ЖИГДЭН

ЗӨВШӨӨРСӨН:

УБ ЦТС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

УБ ЦТС ТӨХК-ИЙН САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

УБ ЦТС ТӨХК-ИЙН АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



С.ТӨМӨРХҮҮ

Б.БАЯСГАЛАН

У.БАЙГАЛМАА